



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 362

Улаанбаатар хот

“Хак кредит ББСБ” ХХК-ийн банк  
бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг  
сунгах тухай

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.3, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 10.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хак кредит ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2013 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад сунгалтын талаарх тэмдэглэгээг 2013 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн дотор хийлгэхийг “Хак кредит ББСБ” ХХК /Ж.Халзанбандид/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавин олон нийтэд мэдээлэж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН